

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

## ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 6 дүүгэр  
сарын 25-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

“Туул сонгино усны нөөц” ХК-ийн үнэт цаасны  
анхдагч зах зээлийн арилжааг зогсоох тухай.

Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 133 дугаар тогтоолын 1-д заасны дагуу үүсгэн байгуулагч Г.Ганбат, Г.Ганцэцэг нарын нэр дээр өмчлөх эрхийг баталгаажуулсан 3 530 829 ширхэг хувьцаанаас Г.Ганбат нь 550 000 ширхэг хувьцааг худалдсан тул үүсгэн байгуулагчдын нэр дээр 2 980 829 ширхэг хувьцаа үлдсэн байна. 2007 оны 133 дугаар тогтоолын хавсралтад заасан 27 530 829 ширхэг хувьцаанаас олон нийтэд 13 200 000 хувьцаа арилжигдсан байна. Г.Ганбат Г.Ганцэцэг нарын нэр дээр өмчлөх эрхийг нь баталгаажуулсан хувьцаанаас тус компанийн анхдагч зах зээл дээр бодитойгоор арилжигдсан хувьцаанд хувь тэнцүүлэн саналын эрх эдлүүлэх, үлдсэн хувьцааг олон нийтэд арилжих хүртэл Г.Ганбат Г.Ганцэцэг нарын дээр өмчлөх эрх нь баталгаажсан бусад хувьцааны хувьд саналын эрхийг эдлүүлэхгүй байх нь шударга ёсонд нийцэх учрыг ТЭМДЭГЛЭН,

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалт болон “Туул сонгино усны нөөц” ХК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн Ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Туул сонгино усны нөөц” ХК-ийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг зогсоохыг “Монголын хөрөнгийн бирж” ХК / Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

2. “Туул сонгино усны нөөц” ХК-ийн гаргасан хувьцааг 15 141 956 ширхэгээр тогтоосугай.

3. “Туул сонгино усны нөөц” ХК-ийн гаргасан хувьцааг 15 141 956 ширхэгээр тогтоосонтой холбогдуулан үүсгэн байгуулагч Г.Ганбатын нэр дээр 1 001 956 ширхэг, Г.Ганцэцэгийн нэр дээр 390 000 ширхэг хувьцааг тус тус хувь тэнцүүлэн саналын эрхтэйг дурьдаж нийт 1 391 956 ширхэг хувьцааг 1 жилийн хугацаанд тусгаарлаж хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулахгүй байхыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

4. 2 980 829 ширхэг хувьцаанаас энэ тогтоолын 3-т заасан 1 391 956 ширхэг хувьцааг хассаны зөрүү болох 1 588 873 ширхэг хувьцааг үүсгэн байгуулагч Г.Ганбатын нэр дээр Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 133 дугаар тогтоолын 1-д туссан 11 859 171 ширхэг хувьцаан дээр нэмж тусгаарлахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5. Анхдагч зах зээлд нийлүүлээгүй үлдсэн 10 800 000 ширхэг хувьцаанаас нийлүүлэлт хийхдээ төслийн хэрэгжилтийн тайлан, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг

холбогдох баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлэн зөвшөөрөл авахыг “Туул сонгино усны нөөц” ХК /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Алишер Джуманов, гүйцэтгэх захирал Марат Утегенов/, андеррайтерийн “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/, Хорооноос олгосон зөвшөөрлийг үндэслэн хувьцааг арилжаалахыг “Монголын Хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д тус тус үүрэг болгосугай.

6. Хувьцаа гаргах үед олон нийтэд танилцуулсан төслийг хэрэгжүүлэх ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцорч байгааг онцгой анхаарч уг арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлангаа 2009 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан Хороонд ирүүлэхийг “Туул сонгино усны нөөц” ХК /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Алишер Джуманов, гүйцэтгэх захирал Марат Утегенов/, андеррайтерийн “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, олон нийтэд мэдээллэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.УДААНЖАРГАЛ